



ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 ОНЫ 6-Р САРЫН 30-НЫ БАЙДЛААР

Агуулга

1. Онцлох үйл явдал	3-5
2. Санхүүгийн үзүүлэлтүүд	6-11
3. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	12-13
4. Компанийн засаглал	14

Онцлох үйл явдал



163.2 сая ам.долларын урт хугацаат гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүллээ.




ХасБанк 2025 оны 2-р улиралд нийт 163.2 сая ам.долларын урт хугацаат гадаад эх үүсвэрийг EBRD, Finnfund, DWM зэрэг байгууллагуудаас амжилттай татан төвлөрүүллээ. Үг санхүүжилтээс 147 сая ам.доллар нь 35 хүртэлх насны залуу бизнес эрхлэгчдийг дэмжихэд зориулагдаж байна.

Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг сунгалаа



ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг Монголбанкны холбогдох зөвшөөрлийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн дахин 6 сарын хугацаанд хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 4,000,000 ширхэг хүртэлх хувьцааг 888 төгрөг хүртэлх үнээр эргүүлэн худалдан авна.

Мерчантуудад зориулсан веб, аппликейшнийг нэвтрүүллээ.



Гүйцээний хуулга бодит цагийн горимоор харах, үйлчилгээний хүсэлт илгээх, урамшуулалт аяны мэдээллийг цаг тухай бүрт авах боломж бүхий мерчантуудад зориулсан веб, аппликейшнийг энэ оны II улиралд амжилттай нэвтрүүллээ.

Цагаан алт, Атар-4 аянд нэгдлээ



Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй "Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих" Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд 27.8 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө, АТАР-4 аяны хүрээнд хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын эзэл" хөтөлбөрийн хүрээнд 8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг хамтран ажилладаг байгууллагуудад олголоо.

ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг амжилттай зохион байгууллаа.



ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Шангри-Ла зочид буудлын их танхимд цахим болон танхим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулагдлаа. Хурал 96.01хувийн нээлтийн ирцтэйгээр хүчин төгөлдөр болж, хувьцаа эзэмшигчид нийт 6 асуудлыг хэлэлцэн баталлаа.

Хагдаламжын урамшуулалт аяныг үргэлжлүүлж байна




Тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх, байнгийн харилцагчаа урамшуулж, харилцагчийн бааз суурийг өргөжүүлэх зорилготой 1 тэрбум төгрөгийн шагналын сантай хадгаламжийн аянг зарласан. Үүний үр дүнд ирээдүйн саятан хадгаламж эзэмшигч 200 мянга давж, хугацаатай хадгаламж, цалингийн хадгаламж, тэтгэвэр хуримтлалын данс эзэмшигчийн тоо 5.8 хувиар нэмэгдсэн байна

Онцлох үйл явдал

2025 оны II улирал

ХасБанк нь нийгмийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулан, залуу үеийнхний бизнесийн санаачилга, идэвхийг дэмжих зорилгоор "Залуу бизнес эрхлэгчийг дэмжих зээл"-ийг 2025 оны 4 сард шинээр нэвтрүүлээ. Үг зээлийн бүтээгдэхүүн нь 35 хүртэлх насны бизнес эрхлэгчид болон гүйцэтгэх удирдлага нь 35 хүртэлх насны залуучуудаас бүрдэх, эсвэл нийт хувьцааны 51 ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь 35 хүртэлх насны залуус байх бизнес эрхлэгчдэд зориулагдсан.

Залуу бизнес эрхлэгчдэд зээл нь барьцаа хөрөнгийн хөнгөлөлттэй давуу талтайгаас гадна зээлийн хүүгийн шаталсан бууралт нь зээлдэгчийн хариуцлагатай, хугацаандаа зээлээ төлөх байдалд тулгуурлан хэрэгжих бөгөөд энэ нь зээлийн хугацаанд хүүний хэмнэлтийг бий болгож, бизнес эрхлэгчдэд санхүүгийн дарамт багасгах эерэг нөлөө үзүүлж байна. Бизнесийн орлого өсөж, үйл ажиллагаа нь тогтворжихын хэрээр зээлийн хүү буурч, харилцагчийн төлбөрийн ачааллыг үе шаттайгаар бууруулах шийдэл нь энэхүү бүтээгдэхүүний онцлог давуу тал болж байна.



Цахим шилжилт

2025 оны II улирал

InstaPay

Төлбөр тооцоогоо хормын дотор, төвөггүй ухаалгаар хийх боломж бүхий InstaPay аппликейшнийг энэ оны 5-р сард нэвтрүүлээ. Тус аппликейшнийг тусад нь суулгах шаардлагагүй дижитал банкны эрхээрээ нэвтрэхэд боломжтой бөгөөд харилцагчид тус аппликейшний "reward" цэснээс төрөл бүрийн урамшуулыг авах боломжтой болсноороо онцлог юм. Оны эхний хагас жилийн байдлаар тус аппликейшн руу 28,000 гаруй хэрэглэгч хандсан байна.



ХасTeen+

7-17 насныханд зориулсан ХасTeen+ аппликейшний эхний хувилбарыг 5-р сард зах зээлд амжилттай нэвтрүүлээ. Тус аппликейшн нь өөрийн давтагдашгүй өнгө төрхийг бүтээж, өдөр тутамын санхүүгээ сонирхолтой, хялбар байдлаар бүрэн удирдах боломжийг хүүхэд залууст олгох юм.



Санхүүгийн үр дүн

2025 оны II улирал

Цэвэр ашиг	ROE	ХАС (хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮85.9 тэрбум	22.6%	₮850.0	₮163.4*	18.3% >12.5%	36.0% >25.0%

Ашигт ажиллагаа

- 2025 оны II улиралд ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 41.8 тэрбум төгрөгт хүрч өссөн дүнгээр хагас жилийн цэвэр ашиг 85.9 тэрбум төгрөг буюу өмнөх жилийн мөн үеэс 0.7% өссөн байна. Тайлант хугацаанд Банкны зээл болон санхүүгийн багцын өсөлт ашигт ажиллагаанд эергээр нөлөөлсөн бол эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаатай эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлсэн нь сөрөг нөлөө үзүүлсэн байна.
- 2025 оны II улирлын байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 22.6%, II улирлын байдлаарх нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 81.7 төгрөг, жилд шилжүүлсэн EPS 163.4 төгрөг байна.

Баланс

- Нийт зээлийн багц өмнөх улирлаас 9.7 хувь өсөж 4,221 тэрбум төгрөгт хүрлээ.
- Иргэдийн банкны зээлийн багц 7.5 хувиар өсөж 2,921 тэрбум төгрөгт хүрэхэд хэрэглээний болон бичил, ЖДБ зээлийн өсөлт нөлөөлжээ.
- ХасЛизингийн санхүүгийн түрээс болон зээлийн багц 20.2 хувиар өсөж 611 тэрбум төгрөг хүрэхэд шинэ болон хуучин авто машины санхүүгийн түрээсийн өсөлт голчлон нөлөөлсөн байна.
- Байгууллагын банкны зээлийн багц өмнөх улирлаас 11.1 хувиар өсөж 690 тэрбумд төгрөгт хүрсэн байна.
- Чанаргүй зээлийн харьцаа 2.2 хувьд хүрч өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар өссөн байна.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ өмнөх улирлаас 1.7 хувиар өсөж 3,421 тэрбум төгрөгт, гадаад эх үүсвэрийн хэмжээ 22.9 хувиар өсөж 606 сая ам.долларт тус тус хүрлээ.

Харьцаа үзүүлэлт

- 2025 оны II улирлын байдлаар Монголбанкнаас тогтоосон харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохистой хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 18.3% буюу доод хэмжээг 5.8%-иар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2025 оны 6 сарын 30-ний байдлаар 36.0% байгаа нь зохистой харьцааг хангаж байна.

* Жилд шилжүүлсэн нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг


Санхүүгийн үзүүлэлтийн тренд



2025 оны II улирал


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг




Нийт актив

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Зээлийн үйл ажиллагаа

2025 оны II улирал

Нийт зээлийн тоо

228.6 мянга ▲ 6.3% QoQ

Иргэдийн банк зээлийн тоо

223.5 мянга

Байгууллагын банк зээлийн тоо

0.2 мянга

ХасЛизинг с.түрээсийн тоо

4.9 мянга

Онлайн зээлийн тоо

154.2 мянга ▲ 7.6% QoQ

Зээлийн багц


Тэрбум төгрөг



Зээлийн багц бизнесийн сегментээр

Тэрбум төгрөг

■ 25-I ■ 25-II



- 2025 оны II улиралд зээлийн багц 9.7 хувь өсөж 4,221 тэрбум төгрөгт хүрлээ. Энэхүү өсөлтөд бичил жижиг бизнесийн зээл, хэрэглээний зээл болон санхүүгийн түрээсийн багцын өсөлт голчлон нөлөөлжээ.
- Шинээр нэвтрүүлсэн "Асуудалгүй" үйлчилгээний хэрэглэгчид өмнөх улирлаас 61.2% өсөж 58 мянгад хүрсэн байна.

Дотоод эх үүсвэр



2025 оны II улирал

Нийт дансны тоо

1.5 сая  3.2% QoQ

Харилцах
дансны тоо

916.4 мянга

Хадгаламжийн дансны тоо


560.3 мянга

“Асуудалгүй” үйчилгээний хэрэглэгчийн тоо

58.6 мянга  61.2% QoQ


Харилцах, хадгаламж

Тэрбүм төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- 2025 оны II улиралд ХасБанкны харилцах дансны үлдэгдэл 733 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 5.9% өссөн байна.
- Уламжлалт салбарын сувгийн үйлчилгээг үргэлжүүлэхээс гадна дижитал, цахим суваг, төлбөр тооцоо, картын бүтээгдэхүүнийг сайжруулахад чиглэсэн хөгжүүлэлт, төслүүд дээр ач холбогдол өгч ажилсны үр дүнд нийт хадгаламж өмнөх улирлаас 0.5 хувиар өсөж 2,688 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Гадаад эх үүсвэр

2025 оны II улирал

2025 оны II улиралд Банк нийт 163.2 сая ам.долларын шинэ эх үүсвэр татан төвлөрүүлээд байна. EBRD, DWM, Finnfund зэрэг байгууллагуудаас татан төвлөрүүлсэн энэхүү эх үүсвэрийг залуу бизнес эрхлэгчид, бичил, жижиг дунд бизнесүүдийг дэмжихэд зориулах юм. Оны эхнээс өссөн дүнгээр нийт 213.2 сая ам.долларын эх үүсвэрийг гадаад банк санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлээд байна.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



Шинэ эх үүсвэрүүд



\$147,000,000

35 хүртэлх насны залуу бизнес эрхлэгчдэд зориулсан синдикат зээлийн эх үүсвэр татлаа.



\$6,200,000

Бичил, ЖДБ-ийг дэмжих зориулалт бүхий энгийн урт хугацаат эх үүсвэр татан төвлөрүүлээ.



\$10,000,000

Бичил, ЖДБ болон ногоон эдийн засгийг дэмжих зориулалт бүхий гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүлээ.

Хувьцааны мэдээлэл



2025 оны II улирал

ХасБанк ХК (ХАС)-ын хувьцааны үнэ 2025 оны 6 сарын 30-нд 849.88 төгрөгөөр хаагдсан нь оны эхнээс 2.9 хувь, IPO хийсэн үнээс 25.5% өслөө. 2025 оны II улирлын байдлаар нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг 81.6 төгрөг, жилд шилжүүлбэл 163.3 төгрөг байна.

ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг Монголбанкны холбогдох зөвшөөрлийн дагуу 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн дахин 6 сарын хугацаанд хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ХасБанк 2025 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 716,441 ширхэг хувьцааг халаасалсан байна.


ХАС хувьцааны ханш, арилжааны хэмжээ



Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг

2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг нэгж хувьцаанд **₮18.0**
2024 оны сүүлийн хагас жилийн ногдол ашиг нэгж хувьцаанд **₮27.0**




*Тус шийдвэрийг Монголбанкнаас зөвшөөрч, Банкны Дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн журлаар эцэслэн баталсны дараагаар ногдол ашгийг тараах юм

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2025 оны II улирал

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

18.3% Байвал зохих доод хэмжээ 12.5%




Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

36.0% Байвал зохих доод хэмжээ 25.0%

Түргэн борлогдох актив

Нийт 2,140.7 тэрбум төгрөг



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2024 I улирал	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.9%	-2.3%	-6.2%	-1.7%	-2.0%	-4.9%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-2.9%	-3.3%	-9.1%	-2.0%	-3.3%	-5.7%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	33.0%	52.9%	56.9%	41.7%	51.7%	46.3%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.4%	1.2%	1.2%	1.2%	1.2%	1.1%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.8%	7.9%	7.4%	7.9%	7.0%	6.8%

	2024 I улирал	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.9%	0.7%	1.7%	2.2%	1.7%	0.9%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	3.0%	2.9%	2.8%	0.0%	0.0%	0.0%

	2024 I улирал	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал	2025 II улирал
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.9%	0.7%	1.7%	2.3%	1.8%	0.9%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.3%	0.5%	0.4%	0.3%	0.3%	0.4%
Банкны бусад холбогдох этгээд	3.0%	2.9%	2.8%	0.1%	0.0%	0.1%

Төлөөлөн удирдах зөвлөлийн болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны хурал

2025 оны II улирал



Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо i) Засаглал, цалин урамшууллын хороо болон ii) Нэр дэвшүүлэх хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах асуудлыг ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцэн баталсан. Улмаар Төлөөлөн удирдах зөвлөл нь 1. Засаглал, цалин, урамшууллын хороо, 2. Нэр дэвшүүлэх хороо, 3. Эрсдэлийн удирдлагын хороо, 4. Аудитын хороо гэсэн бие даасан чиг үүрэг бүхий 4-н хороотой үйл ажиллагаагаа явуулж байна.



☎ (976)-75771888-(888)

✉ investor-relations@xacbank.mn

🌐 <https://www.xacbank.mn>